

## МОНГОЛ, НОРВЕГИЙН 50 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭВ

Written by stockholm


Thursday, 11 January 2018 10:14 - Last Updated Wednesday, 17 January 2018 11:13

---

Монгол Улс, Норвегийн Вант Улсын хооронд Дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн одрийг Норвегийн Вант Улсын нийслэл Осло хотноо 2018 оны 1 дүгээр сарын 11-ний одор тэмдэглэн онгорвув.

Дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Норвегийн ГХЯ-ны Улс торийн газрын Орлогч Ерөнхий захирал Р.Квиль Элчин сайдыг хүндэтгэн үдийн зоог барив. Энэ үеэр Дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлогчоос Норвегийн Цог Жавхлант Хаанд илгээсэн баярын захидлыг уламжилж хоёр улсын Гадаад хэргийн сайд нарын баярын цахилгаан утсыг харилцан солилцох арга хэмжээ болов.

Дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Монгол Улсаас Норвегийн Вант Улсад хавсран суугаа ЭСЯ, Норвеги дахь Оргомжит консулын газартай хамтран Осло хотын тов кино театрын хүндэтгэлийн танхимд Хүлээн авалт зохион байгуулав. Түүнчлэн хүлээн авалтын үеэр хүрэлцэн ирсэн зочдод монголын тухай гэрэл зургийн үзэсгэлэн болон ардын урлагийн тоглолтыг толилуулав. Мон “Чингисийн хүүхдүүд” монголын уран сайхны киноны нээлтийг зохион байгуулав. Хүлээн авалтад Норвегийн ГХЯ-ны удирдлага, монгол-норвегийн найрамдлын нийгэмлэг, Норвегийн Тов банк, норвегийн цаатангийн зовлол, норвегийн иргэд, норвегид оршин суугаа монгол иргэдийн толоолол оргоноор оролцов.



# МОНГОЛ, НОРВЕГИЙН 50 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭВ

Written by stockholm

Thursday, 11 January 2018 10:14 - Last Updated Wednesday, 17 January 2018 11:13

---

